

АНУ-ЫН ГАДААД БОДЛОГЫН ШИЙДВЭР ГАРГАЛТ: КОНГРЕСС БА УЛС ТӨРИЙН НАМУУДЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Пүрэвдоржийн Мянгардорж¹

Abstract: *This research paper aims to determine the position of the Congress, which is mainly involved in making foreign policy decisions of the US, and the political groups working together within the framework of the two main parties, the Republican Party, and the Democratic Party, on foreign policy issues. Among the factions within the Republican Party, the "Neoconservatives" and the "Hardline Conservatives" advocate a more rigid stance on foreign policy decision-making, even the use of military force to protect the nation's interests. However, the 'Trumpists' were formed later in this party, take a different position from the previous two groups in some cases Republican Isolationists take the position of isolating the United States from world politics, and the Traditional Internationalists take the United States to an active position in world politics. Among the groups of the Democratic Party, the Liberal Internationalists are expected to protect the interests of the United States by creating and confirming the international collective security system, and today, the group occupies a significant position in the country's decision-making. Thus, by defining the position of the political group that plays a key role in US foreign policy decision-making, what position does Mongolia take when communicating with the country's influential politicians and other politicians, diplomats, and researchers within their "third neighbor policy", it is possible to predict what foreign policy concepts they will adhere to in dealing with other countries.*

Key Words: *US Congress, Republican Party, Democratic Party, Political Groups.*

Удиртгал

Өнөөгийн дэлхийн улс төр, геополитикийн орчинд үүсээд буй шинэ нөхцөл байдал нь Монгол Улсын гадаад бодлого болон гадаад бодлогын шийдвэр гаргалтад мэдэгдэхүйц сорилтыг авчирч байна. Ялангуяа Монгол Улсын хойд хөрш Орос улс Украинтай дайтаж, өмнөд хөрш Хятад улс Тайваний талаар баримталж буй бодлогоо идэвхжүүлж, мөн Ойрх Дорнодод үүсээд байгаа нөхцөл байдал зэргээс үүдэн “Хүйтэн дайн”-ы дараа тогтсон олон улсын харилцааны дэг журам өөрчлөгдөж буй нь үүнтэй шууд холбоотой. Энэхүү “дэлхийн шинэ дэг журам” нь олон улсын харилцаан дахь АНУ-ын байр суурь, нөлөөний цар хүрээгээр тодорхойлогдож байсан бол дээрх хүчний төлөөх тэмцэл, тогтсон дэг журмыг өөрчлөх оролдлогууд нь БНХАУ болон ОХУ-ын гадаад бодлогын стратегийн зорилго, зорилтуудаар хүчтэй илэрч байна.

Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын 2-р бүлгийн 14.1-т заасанчлан, манай улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл нь хоёр хөрштэйгөө найрсаг харилцаатай байх

ХИС-ийн Олон улс, нийгэм судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D.)

Цахим хаяг: myagmardorj@humanities.mn

явдал билээ. Тус үзэл баримтлалын 14.2-т “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд АНУ тэргүүтэй өрнө дорнын улсуудтай түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх тухай мөн заасан байдаг. (Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал., 2011.)

Өнөөдөр манай улсын гадаад бодлогын өмнө тулгамдаж буй гол асуудал нь өөр хоорондоо сөргөлдөөнтэй байгаа эдгээр их гүрнүүдтэй яаж харилцах, улс эх орныхоо ашиг сонирхлыг хамгаалж үлдэхийн тулд оновчтой зөв шийдвэрүүдийг хэрхэн гаргах явдал юм. Монгол Улсын ашиг сонирхлыг хангасан, эрсдэл багатай, оновчтой зөв шийдвэр гаргахын тулд нэр дурдсан их гүрнүүдийн гадаад бодлогын зорилго зорилтууд, шийдвэр гаргахад нөлөөлдөг хүчин зүйлс, мөн шийдвэр гаргалтын механизмыг судлах шаардлагатай. Ингэснээр Монгол Улсын зүгээс тэдгээр улстай харилцахдаа бодолцож байх хүчин зүйлсийн талаар тал бүрийн мэдээлэл, үнэлэлт дүгнэлттэй байх болно.

Тухайн улсын хэн гэдэг улс төрч, ямар намын улс төрийн аль бүлэгт хамаардгийг мэдэж байвал манай талаас тэдэнтэй харилцаж, асуудлаа уялдуулан шийдвэрлэхэд хялбар дөхөм болно. Олон улсын харилцааны реалист онолын гол төлөөлөгч Ханс Моргентау “*Аливаа улс гадаад бодлогоо амжилттай хэрэгжүүлэхийн тулд нөгөө улсынхаа гадаад бодлогын зорилго зорилтыг заавал мэдэж, тооцоолох ёстой*” хэмээн өгүүлснээс харахад ч энэ талын судалгаа шинжилгээний ажлыг сайтар хийж, бодлогын зөвлөмж боловсруулан шийдвэр гаргагчдад хүргүүлэх нь нэн чухал юм.

Энэхүү судалгааны ажлаараа өнөөгийн олон улсын харилцааны голлох тоглогч, дэлхийн улс төр, геополитикийн орчинд асар их нөлөөтэй АНУ-ын гадаад бодлого, бодлогын шийдвэр гаргалтад томоохон байр суурь эзэлдэг хууль тогтоох байгууллага Конгрессын үүрэг роль, ялангуяа Конгрессын шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй оролцдог АНУ-ын хоёр гол улс төрийн нам болох Бүгд найрамдах нам, Ардчилсан нам, тэдгээрийн доторх голлох бүлгүүдийн байр суурийг тодорхойлохыг зорилоо. Ялангуяа өнөөгийн олон улсын харилцааны нөхцөл байдал нь АНУ-ын гадаад бодлогын өмнө томоохон сорилтуудыг бий болгож байгаа нь гадаад бодлогын эцсийн шийдвэр гаргалтын тухайд дотоод улс төрийн зөрчилдөөнийг үүсгээд байна. Уг зөрчилдөөн нь олон улсын харилцааны ямар асуудал дээр хэрхэн илэрч, аль нам, улс төрийн ямар фракц бүлэглэл нь тэдгээр асуудалд зарчмын хувьд ямар байр сууринаас ханддаг болохыг тодорхой түүхэн бодит жишээн дээр тулгуурлан чанарын судалгаа хийхийг зорилоо.

Үндсэн хэсэг

АНУ-ын засгийн газрын нэг гол үүрэг нь дэлхийн улс орнуудтай харилцах бөгөөд өнөөдөр олон улсын тавцанд ямар байр суурь эзлэж байгаагаар нь тус улсын гадаад бодлого

нь тодорхойлогддог. Түүхийн явцад АНУ-ын үндэсний ашиг сонирхол ба гадаад бодлогын хоорондын харилцан хамаарал мэдэгдэхүйц өөрчлөгдөж ирсэн байдаг. АНУ-ын тусгаар тогтнолын эхний жилүүдэд гадаад бодлогын үндсэн зорилго нь тусгаар тогтнолоо хадгалж үлдэх, Европын их гүрнүүдийн нөлөөллөөс ангид оршин тогтнох байлаа. 19-р зууны турш АНУ-ын төрийн бодлого нь эдийн засгийн хувьд хүчирхэгжих, аж үйлдвэрийн хувьсгалын үр дүнг хойд Америкт хэрэгжүүлэхэд чиглэгдэж байлаа. Уг бодлогын үр дүнд АНУ нь цэрэг эдийн засгийн хувьд Европын гүрнүүдтэй эн зэрэгцэх их гүрэн болж, улмаар гадаад улс орнууд руу хандсан идэвхтэй бодлого явуулах болжээ.

“Монрогийн номлол”, Хавайн арал дахь ноёрхол, цаашлаад Карибын сав газар, Номхон Далайн бүсэд орон зайгаа тэлэх зорилгоор Испанитай хийсэн дайны үр дүн зэрэг нь АНУ-ын гадаад бодлогод эргэлт авчирсан төдийгүй олон улсын харилцааны нэгэн шинэ хүчтэй тоглогч бий болсныг дэлхий дахинд харуулсан юм. Дэлхийн 1-р дайны дараа Европын улс төрийн бодлогод АНУ зохих байр сууриа эзлэх болж, дайны дараах дэлхийн дэг журмыг нэгэн үе тодорхойлж байсан “Үндэстнүүдийн холбоо”-г АНУ-ын ерөнхийлөгч В.Вильсоны санаачлан байгуулсан юм. Дэлхийн 2-р дайнд ялагчдын нэг болсноор НҮБ-ыг байгуулж, “Маршаллын төлөвлөгөө”-ний дагуу Европын улсуудыг эдийн засгийн хувьд хөл дээр нь босгож, улмаар коммунизмын үзэл суртлыг дэлгэрүүлэхгүйн тулд Баруун Европын улс орнуудыг манлайлан чиглүүлж, Умард Атлантын гэрээний байгууллагыг байгуулсан билээ. 1949 оноос хойш Хүйтэн дайныг дуусах хүртэлх хугацаанд Америкийн гадаад бодлого нь коммунизмыг “тогтоон барих бодлого”-оор тодорхойлогдож байв. “Төмөр хөшиг” нуран унаж, ЗХУ задарснаар АНУ нь дэлхийн цорын ганц их гүрэн болсон үеэс эхлэн тус улсын гадаад бодлогын суурь зарчмууд нь ардчиллын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх замаар аюулгүй байдлаа баталгаажуулахад чиглэгдэх болжээ.

Өнөөдөр АНУ-ын гадаад бодлогын зорилго чиглэл нь маш өргөн хүрээг хамрах болсон бөгөөд нэн тэргүүнд тус улс дэлхийн улс төрийн бодлогод эзэлж буй байр сууриа хадгалах, үүний тулд олон улсын энх тайван аюулгүй байдлыг хангах, зэвсэглэлд хяналт тавих, бүс нутгийн хямрал мөргөлдөөнийг зохицуулах, олон улсын санхүүгийн тогтолцоог хэвээр хадгалах, ардчиллын үнэт зүйлсийг дэлхий дахинд улам бүр түгээн дэлгэрүүлэх зэрэг асуудалд голлон анхаарч байна. Америкийн гадаад харилцаанд гарсан түүхэн өөрчлөлтүүдийн нөлөөгөөр Америкийн гадаад бодлогыг хэрэгжүүлэх арга хэлбэр ч мөн адил өөрчлөгдөж ирэв. Яам, агентлаг, албаны нэгж зэрэг засгийн газрын бүтцэд багтдаг байгууллагууд нь АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад оролцдог. Эдгээр институтээс ерөнхийлөгч болон

Конгресс нь АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах механизмд гол байр суурь эзэлдэг. ”Сенатын зөвлөмж, зөвшөөрөлтэйгөөр ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулж, гадаад улсад суух АНУ-ын элчин сайдуудыг томилдог”. (The Constitution of the United States, 1798) Ерөнхийлөгч нь бусад улсын төрийн тэргүүнтэй дээд хэмжээний уулзалт, яриа хэлэлцээ хийхийн сацуу Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувиар дэлхий дахинд АНУ-ын цэргийн бодлогыг хэрэгжүүлэх эрхтэй. (“War and International Law: America’s Foreign Policy: A Brief History”, 2018)

Үндэсний Аюулгүйн Байдлын Зөвлөл, Төрийн Департамент, Батлан Хамгаалах Яам буюу Пентагон, Тагнуулын Төв Газар, бодлогын судалгаа хийдэг тинк танкууд, төрийн бус байгууллагууд болон олон нийт нь гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцад мөн оролцдог. АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцыг сайтар ойлгохын тулд шийдвэр гаргах механизмд багтдаг дээр дурдсан институтуудыг нарийвчлан судлах хэрэгтэй байдаг.

Конгресс ба гадаад бодлогын шийдвэр гаргалт: “Гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд Конгресстэй байр сууриа нийцүүлэх нь ямар чухал болохыг АНУ-ын үе үеийн ерөнхийлөгчид ойлгож ирсэн юм. Гадаад бодлогын шийдвэр гаргалтад Конгрессын дэмжлэгийг авснаар тэд гаргасан шийдвэртэй илүү итгэлтэй байх ба үр дүн ч илүү бодитой болдог. Мөн Америкийн иргэд, олон нийт түүнийг нь дэмжиж байгаа гэдэгт илүү итгэлтэй болдог.” (Biden, 2000)

АНУ-ын Үндсэн хуулийн 1-р зүйлд заасны дагуу гадаад бодлогын тал дээр Конгресс нь тодорхой эрх мэдэлтэй байдаг. Тус зүйлд зааснаар, Конгресс нь “Сенат ба Төлөөлөгчдийн танхимаас бүрдэх бөгөөд бусад улс орнуудтай хийх худалдааг зохицуулах, гадаад улсын иргэдийг АНУ-ын иргэн болгох нэгдсэн журмыг тогтоох, дайн зарлах, зэвсэгт хүчин тэнгисийн цэргийн хүчнийг байгуулан хангамжийг нь бүрдүүлэх, тэнгисийн болон хуурай замын явган цэргийн хүчнийг удирдах, зохицуулах журмуудыг батлан гаргах зэрэг эрхтэй.” Үндсэн хуульд зааснаар, “АНУ-ын ерөнхийлөгч олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хилийн чанадад ажиллах дипломатуудыг томилохдоо Сенатын зөвшөөрлийг авдаг”. (Masters, 2017) Мөн Америкийн улс төрийн тогтолцоонд тэнцвэртэй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг институт бол Конгресс юм. Үндсэн хуулийн 1-р зүйлд Конгрессын эрхийн талаар заахдаа: “Нэгдсэн Улсын засгийн газарт болон холбогдох Департамент, түүний албан тушаалтанд Үндсэн хуулиар олгогдсон бүх эрх мэдэл болон дээр заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд зайлиггүй шаардлагатай хуулиудыг Конгресс боловсруулан гаргах эрхтэй” гэжээ. (The Constitution of the United States, 1798) Тухайлбал, 2015-2017 оны хооронд ажиллаж байсан Конгресс нь Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хэмжээнд электрон

ажиглалтын хуулиас эхлээд Хойд Солонгосын эсрэг хориг арга хэмжээ авах тухай хууль, хил хамгаалах тухай хууль, зэрлэг ан амьтдыг хил дамнуулан худалдаалахтай холбоотой олон хуулийг баталжээ. Мөн нэг онцлох зүйл бол гадаадад террорист халдлагад өртөн хохирсон АНУ-ын иргэд тухайн улсын засгийн газарт гомдол гаргах тухай хуульд ерөнхийлөгч Барак Обама хориг тавьсныг үл хэрэгсжээ.

Бусад улсын нутаг дэвсгэрт АНУ дайн хийх талаар шийдвэр гаргах эрх мэдлийн асуудал нэлээд маргаантай сэдэв юм. Дайн зарлах эсэх асуудал нь Конгресс болон ерөнхийлөгчийн хувьд эрх мэдлийн ялгаатай байдаг гэж үзэж болно. Дайн зарлах эрх мэдэл нь Үндсэн хуульд заасны дагуу зөвхөн Конгресст байдаг боловч цэргийн ажиллагаа эхлүүлэх шийдвэрийг АНУ-ын ерөнхийлөгчид Конгресстэй зөвшилцөлгүйгээр хэд хэдэн удаа гаргасан байдаг.

АНУ-ын ерөнхийлөгчид 1812 оноос эхлээд Англи, Мексик, Испани, Япон болон Европын улсуудтай хийх дайны асуудлаар шийдвэр гаргахдаа Конгрессын зөвшөөрлийг ямагт авч иржээ. Гэхдээ Хүйтэн дайны үед ерөнхийлөгч Х.Трумен Конгрессын зөвшөөрөлгүйгээр, НҮБ-ын далбаан дор АНУ-ын армийг Солонгосын дайнд оролцуулжээ. Үүний дараа ерөнхийлөгч Ж.Кеннеди Өмнөд Вьетнамыг коммунизмын аюулаас хамгаалах нэрийн дор Америкийн цэргийн зөвлөхүүдийг Вьетнам руу илгээсэн бол ерөнхийлөгч Линдон Жонсон “Тонкины булангийн тогтоол” гаргаж, Конгресс дайн зарлаагүй байхад Хойд Вьетнамын эсрэг цэргийн ажиллагаа эхлүүлсэн юм. (Nixon and the War Powers Resolution. 2017) Энэхүү үйл явдлын дараа Конгрессын гишүүд АНУ-ын Конгрессын зөвшөөрөлгүйгээр ерөнхийлөгч дайны ажиллагаа эхлүүлэхийг хориглосон “Дайны эрх мэдлийн тухай хууль” (War Powers Resolution, 1973) батлах санаачилга гаргахад уг хуулийн төслийг “АНУ-ын ерөнхийлөгчийн зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх эрх мэдлийг хязгаарласан” хэмээн ерөнхийлөгч Р.Никсон үзэж хориг тавьсан боловч 2 танхим уг хуулийг батлан гаргасан юм. Гэвч гүйцэтгэх засаглалын эрх мэдлийг нэмэгдүүлэхийг зорьдог олон хүн, түүний дотор нэлээд олон ерөнхийлөгч уг хуулийг эсэргүүцэх, дагаж мөрдөхөөс татгалзах хандлага өнөөдрийг хүртэл АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтын явцаас анзаарагддаг. Үүнд Ливи, Сирид явуулсан АНУ-ын цэргийн ажиллагааг жишээ татаж болно.

“Гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын асуудлаар гарч буй шийдвэрт хяналт тавих томоохон эрхийг Конгресс эдэлдэг” гэж АНУ-ын Гадаад харилцааны зөвлөлийн судлаач Жонатан Мастерс “АНУ-ын гадаад бодлого дахь эрх мэдэл: Ерөнхийлөгч ба Конгресс” хэмээх судалгааны өгүүлэлдээ бичжээ. (Masters, 2017) Конгресс нь төрийн гүйцэтгэх засаглалын

байгууллагуудыг байгуулах, татан буулгах эрхтэй бөгөөд үүний томоохон жишээ нь 1947 онд Тагнуулын Төв Газрыг Конгрессын шийдвэрээр байгуулсан явдал юм. АНУ нь ардчилсан улс болохын хувьд хууль тогтоох төлөөллийн байгууллага болох Конгресс нь тус улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтад чухал байр суурь эзэлдэг болох нь эндээс харагдана. Гэхдээ үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой чухал асуудлаар шийдвэр гаргахад дотооддоо зөрчилдөх явдал АНУ-ын шийдвэр гаргах механизмд байсаар байна. Нэн ялангуяа дайн энхийн асуудал, АНУ-ын үндэсний аюулгүй байдалд үзүүлэх гадаад хүчин зүйлийн нөлөө өсөх зэрэг олон улсын харилцааны нэн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл нь зарим тохиолдолд ерөнхийлөгчийн байр суурьтай зөрчилдөх хандлага түгээмэл ажээ. АНУ-ын Конгрессын болон ерөнхийлөгчийн сонгуульд аль нам олон суудалтай болох, аль намын нэр дэвшигч ялалт байгуулах зэргээс энэ нь мэдээж шууд хамаардаг учраас АНУ-ын шийдвэр гаргалтад тус улсын хоёр гол нам, тэдгээрийн бүтцэд багтдаг улс төрийн бүлэглэлүүдийн байр суурь, онцлогийг авч үзье.

АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалт ба улстөрийн намуудын гүйцэтгэх үүрэг:

АНУ-ын гадаад бодлогыг боловсруулахад Конгресс чухал үүрэг гүйцэтгэдэг тухай дээр дурдсан. Хэдийгээр шийдвэр гаргалтад ерөнхийлөгч тэргүүлэх байр суурьтай оролцох боловч Үндсэн хуульд зааснаар Конгресс болон ерөнхийлөгчийн институт нь засаглалын адил тэгш эрхтэй нэгжүүд юм. Иймээс, ерөнхийлөгчийн гадаад бодлогын шийдвэр гаргалтын алдаа оноо нь Конгрессын дэмжлэгийг авсан эсэхээр хэмжигддэг.

Гадаад бодлогын асуудлаар шийдвэр гаргах эрх мэдлийн хувиарлалтыг АНУ-ын Үндсэн хуулиар зохицуулсан байдаг. Улсаа төлөөлөн ерөнхийлөгч гарын үсэг зурсан олон улсын гэрээг Сенат дээр соёрхон батлахаас гадна ерөнхийлөгчийн томилсон гадаадад суух элчин сайдуудыг мөн Сенат баталгаажуулдаг. Гадаад бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтэд Конгресс хяналт тавихын зэрэгцээ цэрэг дайны ажиллагаа эхлүүлэх шийдвэрийг мөн гаргадаг. АНУ-ын Үндсэн хуулийн дагуу дайны байдал зарлах цуцлах эрх нь Конгресст хадгалагддаг. Тиймээс хилийн чанадад цэрэг илгээх, цэрэг дайны ажиллагаанд оролцох зэрэг асуудлаар ерөнхийлөгч дангаар шийдвэр гаргах нь эрх зүйд үл нийцнэ. Америкийн ард иргэдийн дуу хоолой, байр суурь нь тэдний төлөөллийн байгууллага болох Конгрессоор дамжин уламжлагдах учиртай.

Эдгээр эрх зүйн зохицуулалт нь гадаад бодлогын шийдвэр гаргалтад оролцох Конгрессын оролцоог хангахад юун түрүүн чиглэгдсэн аж. Хүйтэн дайны он жилүүдэд АНУ-ын цэргийг хилийн чанадад илгээх гэх мэт гадаад бодлогын чухал асуудлуудаар шийдвэр

гаргахад Конгресс нь Үндсэн хуулийн дагуу засаглалын гурван салбарын дунд эрх мэдлийн хувиарлалтын тэнцвэржилтийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг түлхүү явуулж иржээ. (Masters, 2017) Гэхдээ гадаад бодлогын шийдвэр гаргалтад Конгресс нь байнга идэвхтэй оролцдог гэвэл алдаатай дүгнэлт болно. Улс хоорондын харилцаа тогтвортой, АНУ-ын аюулгүй байдалд ноцтой заналхийлсэн зүйл үгүй үед Конгрессын оролцоо харьцангуй сул байдаг ч 1980-аад оны Төв Америкийн бүс нутгийн хямрал, 1990-ээд оны эхэн үеийн Персийн булангийн дайн гэх мэт хурцадмал үед ялангуяа ерөнхийлөгчийн шийдвэртэй санал зөрөлдөх үед Конгрессын оролцоо эрс нэмэгддэг.

Гадаад бодлогын асуудлаар Конгресс болон ерөнхийлөгчийн засаг захиргаанаас шийдвэр гаргахад АНУ-ын улс төрийн голлох хоёр хүчин Бүгд найрамдах нам, Ардчилсан намын үзэл баримтлал, гадаад бодлогын талаар баримталж буй байр суурийнх нь ялгаатай байдал ихээхэн нөлөө үзүүлдэг. Хүйтэн дайны үед АНУ-ын гадаад бодлогын үндсэн зорилго нь ЗХУ-ын коммунизмыг “тогтоон барих”-ад чиглэгдэж байсан тул хоёр намын хооронд байр суурь, үзэл бодлын айхтар зөрчилдөөн гардаггүй байсан гэхэд болно. Тэгтэл 2001 оны 9-р сарын 11-ний өдөр болсон террорист халдлагаас улбаалсан Иракийн цэргийн ажиллагааны дараагаас АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад томоохон маргаан, байр суурийн сөргөлдөөн үүсэх болжээ. Хүйтэн дайны үеийн ихэнх хугацаанд гадаад бодлогын чухал асуудлаар шийдвэр гаргахад хоёр нам зарчмын хувьд санал нэгддэг байсан бол өдгөө тэр байдал нэлээд өөрчлөгдсөн. (Kaplan, 2006) АНУ-ын гол хоёр нам үйл ажиллагааны чиглэл, тодорхой тогтсон үзэл баримтлал, тус тусын үнэт зүйлстэй гэж судлаачид үздэг. Хоёр намын байр суурь зарим тохиолдолд нэгдэж, заримдаа зөрчилдөх асуудал гардаг.

Бүгд найрамдах намын байр суурь, үүрэг оролцоо: Бүгд найрамдах нам нь 1854 онд байгуулагдсан бөгөөд 1861 онд тус намаас ерөнхийлөгчид нэр дэвшсэн Авраам Линкольн сонгуульд ялснаас хойш 50 гаруй жил АНУ-ын Конгресс болон ерөнхийлөгчийн сонгуульд илт давуу байдалтай байв. Уг нам нь тухайн үедээ газрыг үнэгүй хувьчлах, боолчлолыг халах зэрэг нэлээд либераль чиг шугам бүхий хөгжлийн бодлого явуулж байв. (A. F. Gilman, 2019) Гэтэл 1912 оны ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Вудро Вильсон ялснаар Бүгд найрамдах намын давамгайлал эцэс болж, 1960-аад оныг хүртэл гол төлөв Ардчилсан нам засгийн эрхийг атгаж байлаа.

1960-аад оны үед АНУ-д өрнөсөн өнгөт арьстны иргэний эрхийн төлөөх тэмцлийн дараагаас энэ хоёр намын үзэл баримтлал тогтворжиж, Бүгд найрамдах нам нь үзэл суртлын хувьд илүү консерватив, Ардчилсан нам нь илүү либераль чиг шугамыг баримтлан гадаад

дотоод улс төрийн бодлогоо явуулах болжээ. Хүйтэн дайны ид үед бүгд найрамдахчууд коммунизмын эсрэг нэлээд хатуу чанга бодлого явуулахыг эрмэлзэж байв. Гэвч “Уотергейт”-ийн хэрэг явдлын дараа бүгд найрамдахчууд гадаад бодлогын шийдвэр гаргах үйл явцаас хэсэг хугацаанд ангид байжээ. Харин Рональд Рейганы үед улс төрийн шийдвэр гаргахад энэ нам дахин оролцох болж, гадаад бодлогодоо “реалполитик”-ийг баримтлах болсон байна.

Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Жорж Буш 2000 оны 11-р сард болсон сонгуульд ялалт байгуулж АНУ-ын 41 дэх ерөнхийлөгчөөр сонгогдсоноор Ардчилсан намаас сонгогдсон Билл Клинтоны үеийн АНУ-ын гадаад бодлогын стратегид мэдэгдэхүйц өөрчлөлт авчирчээ. 2002 оны 9-р сард “АНУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын Стратеги” батлагдахад Сенат дахь бүгд найрамдахчууд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд “Бушийн номлол” буюу “Урьдчилан сэргийлэх дайн”³-ыг явуулахад энэхүү баримт бичиг нь гол үндэслэл болсон хэмээн судлаачид үздэг. (Steven, 2002) Өөрөөр хэлбэл, бүгд найрамдахчууд ерөнхийлөгчийн суудал болон Сенат дахь давуу байдлаа ашиглан Ойрх Дорнодод хийх цэргийн ажиллагаагаа эрх зүйн хувьд баталгаажуулж чадсан ажээ. Хоёр намын хооронд маргаан дагуулсан зүйл заалт бол ялангуяа тус баримт бичгийн 5-р хэсэг байсан ба үүнд “*үл бүтэх улсууд*”⁴ болон *тэдгээрээс дэмжлэг авдаг террорист бүлгүүд нь АНУ, түүний холбоотон, анд нөхдийн эсрэг үй олноор хөнөөх зэвсэг ашиглахаас сэргийлж, террористуудыг зогсооход бэлэн байх ёстой*” (National Security Strategy, 2002) хэмээн заажээ. Энэ зүйл заалт нь АНУ-ын хувьд Иракт цэргийн ажиллагааг эхлүүлэхэд эрх зүйн чухал үндэслэл болсон юм.

Тэгэхдээ, Бүгд найрамдах нам дотор гадаад бодлогын асуудлаар ондоо байр суурь баримталдаг бүлгүүд байдаг. Ялангуяа Орос-Украины дайны асуудал, ерөнхийлөгч Байден Украинд тусламж үзүүлэхийг дэмжиж буй зэрэг нь тус намын доторх фракц, бүлэглэлүүдийн байр суурийн зөрчил ямархуу түвшинд байгааг илтгэн харуулж байна. Тухайлбал, ерөнхийлөгчийн санал болгож буй Украинд үзүүлэх 113 тэрбум долларын тусламж, тэр дундаа нийт тусламжийн 60 орчим хувь буюу 67 тэрбум долларын цэргийн тусламжийн тухай асуудал томоохон маргааныг өдөөгөөд байгаа билээ. Бүгд найрамдах намын нэг том бүлэг болох “Хатуу Консервативчуудын бүлэг” ерөнхийлөгчийн энэхүү санал дээр дөрөөлөн Конгресс дэх байр сууриа бэхжүүлэхийг зорьж байгааг АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимд өрнөж буй үйл явдлаас харж болно. Уг бүлэгт харьялагддаг улс төрчдийн үзэл баримтлал нь үндсэрхэг үзэлд тулгуурласан нэлээд хатуу чиг урсгалд суурилдаг. Тэдний хувьд АНУ нь дэлхий хамгийн

³ “Preventative war”

⁴ Rogue states

хүчирхэг улс бөгөөд энэ байр сууриа хамгаалах нь гадаад бодлогын үндсэн зорилго нь байх ёстой. Олон улсын дэг журмыг тогтооход ямар нэг олон талт механизм бус харин хүчирхэг их гүрэн л гол үүрэг гүйцэтгэх учиртай гэж тэд үздэг. Тэр үүргийг зөвхөн АНУ гүйцэтгэх чадамжтай тул олон улсын харилцаанд бусад улс орнууд ямар үүрэг гүйцэтгэх, ямар байр суурьтай оролцох, тэр бүү хэл ямар засаглалтай байхыг гагцхүү АНУ-ын заавар зөвлөмжөөр тогтооно гэж үздэг. Хатуу консервативчуудын тоонд АНУ-ын ерөнхийлөгч асан Жорж Буш (хүү), дэд ерөнхийлөгч асан Дик Чейни, Батлан Хамгаалахын сайд асан Доналд Рамсфельд нарыг судлаачид оруулдаг. (Karlan, 2006) Мөн АНУ-ын өнөөгийн Конгрессын гишүүд болох Дэн Бишоп, Жош Бричин, Эндрью Клайд, Майкл Клауд нар энэ бүлэгт хамрагдах бөгөөд тэд хатуу консервативчуудын ашиг сонирхлыг илэрхийлж байна. (Warburton, 2023)

Бүгд найрамдах намын дараагийн нэг томоохон бүлэг бол Неоконсерваторчуудын бүлэг юм. Энэ бүлэгт багтдаг улс төрчид нь АНУ ардчиллын үнэт зүйлсийг даян дэлхийд түгээн дэлгэрүүлэх ёстой хэмээн үздэг ба шаардлагатай гэж үзвэл цэргийн хүч ашиглахыг зүй ёсны хэрэг хэмээн тооцдог. Америкийн неоконсерватизмийн эцэг Ирвин Кристол энэ бүлгийн үзэл санааг бий болгоход жинтэй хувь нэмэр оруулсан нэгэн ажээ. Тэрээр “Вийкли Стандарт” сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэлдээ Фукидидээс эш татан “*хүчтэй нь тулгаж, хүчгүй нь хүлээж авах*” зарчмыг их гүрний хувьд гадаад бодлогодоо АНУ баримтлах ёстой гэж бичсэн байдаг. (Kristol, 2003) Америкийн аюулгүй байдлыг хамгаалж, олон улсад тогтвортой байдлыг бий болгоход ардчиллын үзэл санаа чухал гэж ерөнхийлөгч Вудро Вильсон үзсэн бөгөөд түүний засаглалын үеэс ардчиллыг түгээн дэлгэрүүлэхэд АНУ онцгой анхаарах болжээ.

Неоконсервативчуудын хувьд ардчиллыг түгээн дэлгэрүүлэхэд цэргийн хүч чухал гэж үздэг бөгөөд неоконсерватуудыг заримдаа “автомат буутай Вильсончууд” гэж хочилдог аж. (Karlan, 2006) Неоконсерватууд Афганистан, Ирак дахь АНУ-ын цэргийн ажиллагааг сайшаан дэмжсэн төдийгүй Сири, Иран, Африкийн зарим улсад цэргээ оруулахыг хүчтэй уриалж байсан билээ. Неоконсерватуудын эгнээнд Ж.Бушийн үед Батлан хамгаалахын дэд сайд, Дэлхийн Банкны ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Пол Вульфовиц, “Лос Анжелес” сонины нийтлэлч Чарльз Краутхаммер, олон улсын харилцаа судлаач, нэрт эрдэмтэн Самуэль Хантингтон, “Шинэ Америкийн зууны төсөл” тинк-танкийг үндэслэгч, нэрт гадаад бодлого судлаач Роберт Каган зэрэг нөлөө бүхий улс төрч, судлаач, сэтгүүлчид багтахтаас гадна “Гадаад

харилцааны зөвлөл”⁵, “Өв уламжлалын сан”⁶, “Америкийн бизнесийн хүрээлэн”⁷ зэрэг нэр хүндтэй тинк танкууд тэднийг дэмжин ажилладаг.

АНУ-ын “изоляциянист гадаад бодлого”-ын уламжлалыг хадгалахыг зорьдог намын бүлэг бол Бүгд Найрамдах Изоляционист Бүлэг юм. АНУ-ын изоляционист буюу тусгаарлах бодлого баримтлагчдын түүх 18-19-р зууны заагаас эхлэлтэй. АНУ-ын 5 дахь ерөнхийлөгч Ж.Монрогийн нэрээр алдаршсан “Монрогийн Номлол” нь энэ улсын изоляционист гадаад бодлогын анхны томоохон стратеги гэж ойлгож болно. Тухайн үед шинээр тусгаар тогтнолоо зарласан АНУ нь Европын колончлогч улсуудын асуудалд үл оролцох, тэднээс ангид тусдаа байх бодлого баримталж байсан. Энэ үзэл баримтлал нь Дэлхийн 2-р дайныг хүртэл АНУ-ын гадаад бодлогод томоохон байр суурь эзэлсээр ирсэн юм.

Өнөө үед изоляционистуудыг үндсэн хоёр хэсэгт хуваадаг ба нэг дэх хэсэгт нь хилийн чанадад өрнөж буй үйл хэрэгт АНУ ач холбогдол өгөлгүй харин дотоод асуудлаа шийдвэрлэх хэрэгтэй хэмээн үздэг сонгодог изоляционистууд багтдаг бол хоёр дахь хэсэгт нь “АНУ-ын нутаг дэвсгэр дээр муу зүйл болохоос урьдчилан сэргийлэх бодлого”-ыг баримтлагчид багтана. Энэ хоёр дахь бүлэгт хамаарах улс төрчид, судлаачид нь АНУ-ын хилийн хамгаалалтыг чангатгах, татвар төлөгчдийн мөнгийг хэмнэх, Америкийн зах зээлийг хамгаалах зэрэг бодлогыг дэмжин сайшаадаг байна. Эдгээр улс төрчид нь хилийн чанадад явуулж буй цэргийн ажиллагаа бол татвар төлөгчдийн мөнгийг үрэн таран хийж буй явдал хэмээн нотолдог. Жишээ нь, тэд нэгэн цагт Ардчилсан намын протекционист бүлгийнхэнтэй хамтран Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээрийг эсэргүүцэж байв. Орос Украины дайны эхэлсний дараа энэ бүлгийн байр суурь улам идэвхжиж, Украинд үзүүлэх тусламжийн асуудлаар эрс эсэргүүцсэн байр суурийг баримтлах болсон юм. Тэд, АНУ Украиныг орхиж, Оросын дарангуйлагч Владимир Путинд агуу, түүхэн ялалтыг нь өгөх ёстой гэж үзэж байгаа бөгөөд тэр намын бүлгийн гишүүдийн тоо өссөөр байна. (May, 2023) Энэ бүлэгт АНУ-ын ерөнхийлөгч асан Х.Хувер, ерөнхийлөгчийн сонгуулийн сунгаанд өрсөлдөж байсан АНУ-ын Конгрессын гишүүн Рон Пол нар багтдаг.

Бүгд найрамдах намын өөр нэг бүлэг бол уламжлалт интернационалист бүлэг юм. Энэ бүлгийн улс төрчид АНУ-ын ашиг сонирхолд нийцсэн идэвхтэй гадаад бодлогыг дэмждэг. Уламжлалт реалист онолын дэг сургуулийн төлөөлөгчдийн нэгэн адил эдгээр улс төрч,

⁵ Council on Foreign Relations (CFR)

⁶ Heritage Foundation

⁷ American Enterprise Institute

судлаачид нь олон улсын харилцаанд хүчний тэнцвэрт байдлыг тогтоох ёстой гэж үздэг ба ингэснээр олон улсын аюулгүй байдал тогтворжино хэмээн нотлодог. Нэг ёсондоо олон улсын харилцааг эмх замбараагүй, аюултай, дайн гарах магадлал өндөр хэдий ч зэр зэвсэг, дипломат ажиллагаа, олон талт үйл ажиллагааны үр дүнд зохицуулах боломжтой гэж тооцдог. Хатуу консервативчуудаас ялгаатай нь эдгээр улс төрчид бусад улсыг ямар засаглалтай байхыг нь нэг их чухалчилдаггүй бөгөөд хамгийн гол нь тэр улс орнуудтай хэл амаа ололцдог байх нь л АНУ-ын гадаад бодлогын гол зорилго байх ёстой гэдэг. Энэхүү бодлогыг дэмжигчдийн тоонд АНУ-ын Төрийн Нарийн Бичгийн Дарга, ҮАБ-ын Зөвлөх асан Хэнри Киссинжер, Жорж Бушийн ҮАБ-ын Зөвлөхөөр ажиллаж байсан Brent Scowcroft нарыг оруулдаг.

Бүгд найрамдах намын доторх өөр нэг шинэ бүлэг бол Трампист Бүлэг юм. Тус бүлгийг АНУ-ын 45 дахь ерөнхийлөгч Дональд Трапмын улс төрийн үзэл санаа, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж буй нөлөөлөл, засаглалын арга барилыг дэмждэг, харьцангуй сүүлд бий болсон (2016 оны ерөнхийлөгчийн сонгуулийн сунгаанаас эхтэй) бүлэг гэж тооцож болно. Гэхдээ зарим судлаачид энэ бүлэгт хамаарагддаг улс төрчдийг яг тодорхой нэг бүлэгт багтааж үзэхэд эргэлзээтэй хэмээн нотлодог. (Gordon, 2018) Нөгөөтээгүүр, АНУ-ын улс төрийн хүрээнд түгээмэл хэрэглэгдэх болсон “Трамписм” хэмээх үзэл санааг дэмждэг улс төрчдөөс бүрдсэн хэсгийг Трампистууд гэдэг ба энэ хэсэгт багтдаг улс төрчдийн бүлгийг АНУ-ын улс төрийн хэт барууны чиг шугамыг баримталдаг хэмээн мөн тодорхойлдог байна. (Lowndes, 2019) Трампистуудын гадаад бодлого нь “Америк нэгт”⁸ гэдэг уриагаар тодорхойлогддог. Энэ бодлого нь бусад улстай харилцах эдийн засгийн харилцаа болон холбоотны харилцаанд юун түүрүүнд АНУ-ын ашиг сонирхолыг дээдлэх зарчмаар илэрч байв. Жишээлбэл, АНУ-ын уламжлалт холбоотон гэж тооцогддог Канад болон НАТО-гийн гишүүн Европын улсуудтай харилцах харилцааг үл тоомсорлох хандлагаар илэрч байсан. Эсрэгээрээ “авторитар” хэмээн тооцогддог улсуудын удирдагчидтай харилцах асуудалд голлон анхаарч, зарим тохиолдолд тэдгээр улсын удирдагчдын улс орноо удирдах арга барил, бодлого шийдвэрүүдийг таашаан дэмжих хүртэл байр суурийг илэрхийлж байсан. Тухайлбал, ОХУ, БНХАУ, БНАСАУ-ын удирдагчидтай харилцах асуудал Дональд Трамп, түүнийг дэмжигч улс төрчдийн хувьд АНУ-ын гадаад бодлогын чухал асуудал байв. Трампистуудын бодлогод том байр суурь эзлэж байсан бас нэг асуудал бол хууль бус цагаачдын асуудал бөгөөд баримталж байсан хатуу байр суурь, бодлогоосоо шалтгаалан Латин Америкийн зарим улсуудтай харилцах харилцаагаа

⁸ “America First” хэмээх уриаг ингэж буулгав.

хүйтрүүлж амжсан байдаг. Дональд Трамп болон түүнийг дэмжигчдийн эдгээр байр суурь, бодлого нь гадаад улсуудад мөн тодорхой дэмжлэгийг хүлээж байсан бөгөөд хэт барууны бодлого явуулдаг улс төрчид Европ, Латин Америкийн орнуудад ч идэвхжиж эхэлсэнээс харахад энэ бүлгийн нөлөө хэр их байсныг дүгнэж болно. Дональд Трампын гадаад бодлогын үзэл баримтлалыг дэмжигчдийн тоонд АНУ-ын Төрийн Нарийн Бичгийн Дарга асан Майк Помпео, дэд ерөнхийлөгчийн ҮАБ-ын зөвлөх асан Кейт Келлог нарыг багтаадаг.

Ардчилсан намын байр суурь, үүрэг оролцоо:

АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргах асуудлаар Ардчилсан нам болон Бүгд найрамдах намын төлөөллүүдийн байр суурь зөрчилдсөн хамгийн анхны томоохон жишээ бол Версалийн гэрээг соёрхон батлах асуудал байсан юм. Парисын бага хурлын үр дүнд батлагдсан Версалийн гэрээнд 1919 оны 6-р сарын 28-нд АНУ-ын тухайн үеийн ерөнхийлөгч, Ардчилсан намаас нэр дэвшигч Вудро Вильсон улсаа төлөөлөн гарын үсэг зурсан хэдий ч Сенатад дийлэнх суудлыг эзлэж байсан бүгд найрамдахчууд уг гэрээг соёрхон батлахаас татгалзсанаар Европын улс төрийн тоглолтод оролцох бололцоогоо АНУ хязгаарласан төдийгүй, Үндэстнүүдийн холбооны гишүүн болох боломжоо алдсан байдаг. Ардчилсан засаглал бүхий АНУ-ын хувьд голлох улс төрийн намуудын байр суурь ялгаатай байдлаас шалтгаалан гадаад бодлогын асуудал дээр зарим тохиолдолд нэгдмэл байж чаддаггүйн жишээ энэ болсон юм.

20-р зуунд АНУ-ын гадаад бодлогын үзэл баримтлал бүрэлдэн тогтоход томоохон нөлөө үзүүлсэн улс төрч бол 28 дахь ерөнхийлөгч Вудро Вильсон юм. А.Линкольноос хойш АНУ-ын шийдвэр гаргалтын түвшинд байр сууриа алдаад байсан Ардчилсан нам В.Вильсоны үеэс гадаад бодлогыг тодорхойлоход жинтэй байр суурь эзлэх болжээ.

АНУ-ын үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад нөлөөлөх нэг чухал зүйл нь олон улсын аюулгүй байдал тогтвортой байх явдал юм. Олон улсын харилцаанд энх тайвныг тогтоож, аюулгүй байдал бий болгоход шаардлагатай зүйл нь дэлхийн улс орнууд либераль-ардчилсан болох явдал хэмээн 1917 онд В.Вильсон АНУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын үндсийг тодорхойлжээ. Түүний энэхүү үзэл баримтлалаар АНУ-ын 20-р зууны гадаад бодлого тодорхойлогдож байсан ба өнөөдөр ч энэ байдал хэвээр байна.

Либераль үнэт зүйлсийг аядуу замаар түгээн дэлгэрүүлэх бодлогыг цааш нь үргэлжлүүлсэн улс төрчид бол Ардчилсан намаас ерөнхийлөгч болсон Франклин Рузвельт, Жон Кеннеди нар юм. Хүйтэн дайны дараа АНУ-ын ерөнхийлөгч болсон Билл Клинтоны гадаад бодлого нь мөн л ардчиллыг түгээн дэлгэрүүлэх, Хүйтэн дайнд ялсан ялалтаа баталгаажуулах, олон улсын энх тайван аюулгүй байдлыг сахин хамгаалахад чиглэгдэж байв.

Гэвч 21-р зуун гарснаас хойш олон улсын харилцаанд АНУ-ын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц олон асуудал бий боллоо. АНУ-ын улс төрийн бодлогыг бүгд найрамдахчууд тодорхойлох болж, гадаад бодлогын шийдвэр гаргалтад неоконсервативчууд болон хатуу консервативчууд голлох боллоо.

2008 оны АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Барак Обама ялалт байгуулсан бөгөөд тэрээр Нобелийн энх тайвны шагнал хүртсэн АНУ-ын 3 дахь ерөнхийлөгч болсон юм. “Олон улсын дипломат ажиллагаа, хүмүүс хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулсан онцгой хувь нэмэр”-ийг нь үнэлэн түүнд энэ шагналыг олгожээ. (Erlanger, 2009,) Тэгэхдээ түүний ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеэр танилцуулж байсан гадаад бодлогын зорилтууд болох Иракийн дайныг дуусгах, бүх нийтийн аюулгүй байдалд заналхийлж буй асуудлын эсрэг хамтын эвсэл холбоо байгуулах зэрэг санаа нь Нобелийн шагнал авахад нөлөөлсөн гэж зарим судлаачид үздэг. Эндээс харахад, Ардчилсан намын баримталж буй АНУ-ын гадаад бодлогын талаарх байр суурь нь ардчиллын үнэт зүйлсийг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх үзэл баримтлалаар тодорхойлогдож байна. Бүгд найрамдахчууд энэ бодлогыг шаардлагатай гэж үзвэл хүчээр хэрэгжүүлэх тал дээр хатуу зогсдог бол Ардчилсан намынхны хувьд харьцангуй аядуу замаар хэрэгжүүлэхийг зорьдог юм.

Ардчилсан намын хувьд бүгд найрамдахчуудын нэгэн адил мөн тодорхой үзэл суртлын бүлгүүдэд хуваагддаг. АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад эдгээр бүлгүүд тодорхой нөлөө үзүүлдэг болох нь АНУ-ын гадаад бодлого, дипломатын өнгөрсөн түүхээс тодорхой харагддаг. Эдгээр бүлгийн тэргүүнд либераль-интернационалистууд бичигдэнэ. Ардчиллын үнэт зүйлсийг дэлхийд түгээн дэлгэрүүлснээр олон улсын аюулгүй байдал тогтвортой байх болно гэдэг Вильсоны үзэлд тэд неоконсервативчуудын адил итгэдэг. Тэгэхдээ энэ зорилгод хүрэхийн тулд хүч хэрэглэх бус харин олон улсын аюулгүй байдлын хамтын механизмыг бий болгох замаар хүрэх хэрэгтэй хэмээн тэд нотолдог. (Kaplan, 2006) Өөрөөр хэлбэл, олон үндэстнээс бүрдсэн аюулгүй байдлын байгууллага, институтыг байгуулах хэрэгтэй. Энх тайвныг тогтоохын тулд ардчиллыг түгээн дэлгэрүүлэхээс гадна АНУ-ын холбоотон улсуудаас бүрдсэн олон улсын эвсэл холбоог байгуулан бэхжүүлэх тал дээр түлхүү анхаарч ажилладаг. Үүнээс үзэхэд, либераль-интернационалистууд улс төрийн реализмын онолыг гадаад бодлогын шийдвэр гаргалтад ашигладаг болох нь харагдаж байна. Энэхүү бүлэгт Ардчилсан намын нөлөө бүхий улс төрчид болох Билл Клинтон, Жон Керри, Жозеф Байдан нараас гадна Жимми Картерын ҮАБ-ын зөвлөх асан Збигнев Бжежинскийг оруулдаг.

Ардчилсан намын бас нэг хүчтэй бүлэг нь протекционист бүлэг юм. Бүгд найрамдах изоляционистуудын нэгэн адил Ардчилсан намын протекционист бүлгийнхэн нь “*үндэсний баялаг, хөрөнгө мөнгө нь зөвхөн улсын дотоод үйл амьдрал, сайн сайханд л зориулагдах учиртай. Хэрэв гадагшаа чиглэсэн асуудалд хөрөнгө мөнгө зарцуулах гэж байгаа бол тийм хөрөнгө нь зөвхөн дотоод аюулгүй байдлын төлөө зориулагдах ёстой. Мөн АНУ-ын аюулгүй байдлын ачаанаас үүрэлцэж чадах холбоотон улсуудын тоог нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй*” хэмээн үздэг. Зарим нэг протекционистууд⁹ АНУ нь идэвхтэй гадаад бодлого явуулж, олон улсын үйл хэрэгт хэт ихээр оролцох нь эргээд үндэсний эрх ашигт эерэг гэхээсээ илүү сөрөг үр дагавар авчрах магадлалтай хэмээдэг. Протекционистууд зарим тохиолдолд бүгд найрамдах изоляционистуудтай лобби бүлэг байгуулан чөлөөт худалдааны чиглэлээр батлагдаж буй хууль тогтоомжинд хориг тавих замаар байр сууриа баталгаажуулахыг зорин ажилладаг.

Либераль интернационалистуудын нэгэн адил олон улсын харилцаан дахь АНУ-ын идэвхтэй оролцоог дэмждэг өөр нэг бүлэг бол “нэг асуудлын бүлэг” юм. Тэднийг заримдаа “нийгмийн халамжийн интернационалистууд” хэмээн нэрлэх тохиолдол ч бий. Тус бүлгийн улс төрчид дэлхийн улс төрийн бодлогод оролцох АНУ-ын оролцоог тодорхой асуудлууд дээр идэвхжүүлэх байр суурь баримталдаг. Тухайлбал халдварт өвчин, ядуурал гэх мэт хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд их гүрний хувьд АНУ-ын оролцоо өндөр байх ёстой гэж үздэг. Олон улсын харилцааны тодорхой асуудлыг шийдэхдээ хүч хэрэглэхээс илүү хүмүүнлэгийн тусламж үзүүлэх замаар гадаад бодлогынхоо зорилгыг хэрэгжүүлэхэд анхаарах ёстой гэж үздэг бөгөөд энэхүү бодлогын үндэс суурь нь тэдний ёс суртахууны өндөр хэм хэмжээ байх ёстой ажээ. Гайти, ӨАБНУ, Мьянмар болон Израил зэрэг улсад явуулсан АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад энэ бүлгийн улс төрчид ихээхэн нөлөө үзүүлжээ. (Karlan, 2006)

Гадаад бодлогын шийдвэр гаргалтын талаар судалгаа хийдэг олон судлаач, улс төрчид АНУ-ын явуулсан “терроризмын эсрэг дайн” болон “Иракийн дайн”-ы асуудлаар янз бүрийн шүүмжийг дэвшүүлэн маргадаг боловч зөвхөн “дайн”-ы асуудалд төвлөрдөг бүлэг Ардчилсан намд байдаг бөгөөд уг бүлгийг “дайны эсрэг бүлэг” гэж нэрлэдэг. Энэхүү дайны эсрэг бүлгийн зарим улс төрчдийн баримталдаг байр суурь нь зөвхөн ёс суртахууны хэм хэмжээн дээр

⁹ Тухайлбал: АНУ-ын баримтат киноны алдартай найруулагч Майкл Мур гадаадад хийж буй АНУ-ын цэргийн ажиллагааг хурцаар шүүмжлэдэг бөгөөд энэ нь үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхолд сөрөг үр дагавар авчирч буй талаар хэд хэдэн баримтат кино бүтээсэн юм.

тогтдог энх тайванч бодлого аж. Нөгөө нэг хэсэг нь “дайн хийх нь үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй”, “иргэний эрх чөлөөг хязгаарлаж буй явдал” гэж үзэн АНУ-ын гадагшаа хийж буй дайныг шүүмжилдэг. Гэсэн хэдий ч дайны эсрэг байр суурь баримталдаг улс төрчид Конгресс болон Ардчилсан намд цөөхөн байдаг.

Дүгнэлт

АНУ-ын гадаад бодлого, бодлогын шийдвэр гаргах үйл явцад Ерөнхийлөгч, Конгресс, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төрийн департамент, Батлан хамгаалах яам, Тагнуулын төв газар, тинк-танк хүрээлэнгүүд, төрийн бус байгууллагууд, болон ард иргэд гэх мэт олон оролцогчид нөлөөлж оролцдог. АНУ нь ардчилсан улс болохын хувьд хууль тогтоох төлөөллийн байгууллага болох Конгресс, тэр дундаа Конгрессын дээд танхим Сенат нь тус улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтад ерөнхийлөгчийн хамтаар чухал байр суурь эзлэдэг болох нь харагдаж байна. Тэгэхдээ, үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой, чухал асуудлаар шийдвэр гаргахад дотроо зөрчилддөг байдал АНУ-ын шийдвэр гаргах механизмд байсаар байна. Нэн ялангуяа дайн энхийн асуудал, АНУ-ын үндэсний аюулгүй байдалд үзүүлэх гадаад хурцадмал асуудал зэрэг олон улсын харилцааны нэн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргах эрх мэдэл нь зарим тохиолдолд ерөнхийлөгчийн байр суурьтай зөрчилдөх хандлага түгээмэл ажээ. Энэ нь АНУ-ын Конгрессын болон Ерөнхийлөгчийн сонгуульд аль нам олон суудалтай болох, аль намын нэр дэвшигч ялалт байгуулах зэргээс мэдээж шууд хамаардаг.

АНУ-ын улс төрийн орон зайд Бүгд найрамдах нам болон Ардчилсан нам гэсэн хоёр гол нам оршин тогтнож, ардчиллын зарчмын дагуу дийлэнх сонгогчдын санал авсан нам нь Конгресст олонхи болж, сонгуульд ялсан намын улс төрч АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдон ажилладаг. Ингэж сонгогдсон нам, улс төрч нь тус улсын гадаад бодлогын гол чухал шийдвэрүүдийг гаргадаг. Ингэснээр тухайн нам, улс төрчийн олон улсын харилцааны асуудлаарх байр суурь, үзэл баримтлал, үнэт зүйл зэрэг нь тухайн улсын бодлого, шийдвэр болж гардаг. Тэгвэл энэ хоёр намын голлох бүлгүүд нь гадаад бодлого, олон улсын харилцаатай холбоотой нэн чухал асуудлуудаар шийдвэр гаргахдаа тодорхой байр суурийн зөрчил бүхий үзэл санаа, онол номлолд тулгуурладаг. Тэрхүү үзэл санааны тухайд хоёр нам болон тэдгээрт хамаардаг улс төрийн бүлэглэлүүдийг авч үзвэл Бүгд найрамдах нам нь олон улсын харилцааны асуудлаар шийдвэр гаргахдаа консерватив байр суурь баримталдаг бол,

Ардчилсан нам нь илүү либераль ардчилсан үнэт зүйлсэд тулгуурласан гадаад бодлого явуулдаг байна.

Бүгд найрамдах намын хүрээнд неоконсерваторуудын, бүгд найрамдах изоляционист, хатуу консервативчуудын, уламжлалт интернационалист, трампист зэрэг гол гол бүлгүүд багтаж үйл ажиллагаа явуулдаг. Харин Ардчилсан намын хүрээнд либераль-интернационалистууд, протекционист, “нэг асуудлын” болон “дайны эсрэг” зэрэг бүлгүүд багтдаг. Бүгд найрамдах намаас неоконсервативчуудын болон хатуу консерватуудын бүлэг нь АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад нэлээд хатуу байр суурьтай байж, тус улсын ашиг сонирхлыг хамгаалахад цэрэг дайны хүчийг ашиглахыг дэмждэг. Харин уламжлалт интернационалист бүлгийнхэн АНУ-ын ашиг сонирхлыг ханган хамгаалахад олон улсын яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа, олон талт механизмыг чухалчилж үздэг. Ингэснээр энэ бүлгийнхэн нь зарим асуудлаар Ардчилсан намын либераль-интернационалистуудтай илүү санал нийлдэг болох нь харагдана. Харин 2016 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас оролцож ялалт байгуулсан Дональд Трампыг дэмждэг улс төрчдийг Трампист бүлэгт багтааж үздэг бөгөөд энэ бүлгийнхэн “*Америк нэгт*” хэмээх уриа бүхий АНУ-ын ашиг сонирхлыг хамгийн эхэнд тавих үзэл санаанд тулгуурлан бодлогын шийдвэр гаргахыг эрмэлздэг. Ингэснээр хэдийгээр асуудалд консерватив байдлаар хандаж байгаа мэт боловч нөгөө хоёр бүлгээсээ нэлээд ялгаатай. АНУ-ын өрсөлдөгч “дайсан” хэмээн тооцогддог улсуудтай харилцах харилцааг Дональд Трамп илүүд үзэж уламжлалт холбоотон улсуудтай харилцах харилцааг дордуулсан нь Бүгд найрамдах намын зарим улс төрчдийн зүгээс ихээхэн шүүмжлэлийг хүлээсэн байдаг.

Ардчилсан намын хувьд, дээр дурдсанчлан, либераль үнэт зүйлсэд тулгуурласан гадаад бодлогын чиг шугамыг баримталдаг. Ялангуяа, энэ намын хамгийн хүчтэй бүлэг болох либераль-интернационалистууд нь хамтын аюулгүй байдлын тогтолцоонд олон улсын хамтын ажиллагааг бий болгож, баталтгаажуулах замаар хүрнэ гэж үздэг. Мөн АНУ-ын үнэт зүйлсийг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх нь энэ бүлгийн хамгийн чухал зорилт юм. Энэ асуудлаар Бүгд найрамдах намын неоконсервативчуудтай санал нийлдэг. Энэ бүлэгт Ардчилсан намын голлох улс төрчид багтдагаас АНУ-ын одоогийн ерөнхийлөгч Жозеф Байденийг онцлох хэрэгтэй. Түүний засгийн газрын гадаад бодлогын гол тулгамдсан асуудал бол мэдээж хэрэг олон улсын харилцаанд АНУ-ын байр суурийг хадгалан үлдэхэд оршиж байна. Нэн ялангуяа Украины эсрэг хийж буй ОХУ-ын дайн, үүнтэй холбоотой НАТО-г бэхжүүлэн өргөтгөх,

БНХАУ-ын хүчирхэгжилт, түүнээс үүдэлтэй Энэтхэг-Номхон Далайн бүс дэх стратегийн хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэн бэхжүүлэх зэрэг асуудалд илүүтэй анхаарч байна. Ардчилсан намын бусад бүлгийн хувьд олон улсын харилцаа, АНУ-ын гадаад бодлогын асуудлаар төдийлөн хүчтэй байр суурь илэрхийлдэггүй байна.

Ийнхүү АНУ-ын гадаад бодлогын шийдвэр гаргалтад гол нөлөө үзүүлдэг улс төрийн нам, бүлгийнхний байр суурь, оролцоог бага ч болов тодорхойллоо. Ингэснээр, Монгол Улс гадаад бодлогынхоо “гуравдагч хөрш”-ийн үзэл баримтлалын хүрээнд АНУ-ын голлох улс төрчид, тэдний бүлэгт багтдаг бусад улс төрч, дипломат, судлаачидтай харилцахдаа тэдгээр нь гадаад бодлогын ямар байр суурь, үзэл баримтлалыг баримталж улс орнуудтай харилцдаг болохыг урьдчилан таамаглах нөхцөл боломж бүрдэж байна.

Ашигласан эх сурвалж

- "*War and International Law: America's Foreign Policy: A Brief History*". (2018). Constitutional Rights Foundation: <http://www.crf-usa.org/war-in-iraq/foreign-policy.html>
- A. F. Gilman. (2019). "*The Origin of the Republican Party*". Wisconsin Historical Society: <https://wisconsinhistory.org>
- Biden, S. J. (2000). "A Democratic viewpoint: Congress and Foreign Policy". U.S Foreign Policy Agenda. *An Electronic Journal of the Department of State, Volume 5*, 16-19.
- Erlanger, S. (2009, оны October 9). "Barack Obama Wins Nobel Peace Prize". *The New York Times*.
- Gordon, P. E. (2018). The Authoritarian Personality Revisited: Reading Adorno in the Age of Trump. W. In Brown, P. E. Gordon, & M. Pensky-Д, *Authoritarianism: Three Inquiries in Critical Theory* (хууд. 160). Chicago: Chicago: University of Chicago Press.
- Kaplan, E. (2006). "U.S Political Parties and Foreign Policy". *Council on Foreign Relations*.
- Kristol, I. (2003 оны August 25). "Neoconservative Persuasion". *The Weekly Standard*.
- Lowndes, J. (2019). Populism and race in the United States from George Wallace to Donald Trump. C. (. In de la Torre-Д, *Routledge Handbook of Global Populism* (хуудсд. pp. 197–200). London & New York: London & New York: Routledge.
- Masters, J. (2017). "U.S. Foreign Policy Powers: Congress and the President," . *The Council on Foreign Relations*.
- May, C. D. (2023 оны August 22). *Foundation For Defence of Democracies*. Foundation For Defence of Democracies: <https://www.fdd.org/analysis/2023/08/22/the-problem-with-republican-isolationism/>
- National Security Strategy*. (2002). www.state.gov: <https://www.state.gov/documents/organization/63562.pdf>
- Nixon and the War Powers Resolution*. (2017). Bill of Rights Institute: <https://billofrightsinstitute.org/educate/educator-resources/lessons-plans/presidents-constitution/war-powers-resolution>
- Steven, W. (2002 оны april 13). Editorial Observer; President Bush and the Middle East Axis of Ambiguity". *The New York Times*.
- The Constitution of the United States*. (1798). constitutionus.com: <http://constitutionus.com>

War Powers Resolution. (1973 оны Nov 7).

Warburton, G. S. (2023. January 7). *REUTERS*.

<https://www.reuters.com/world/us/who-are-hardline-us-house-republicans-voting-against-mccarthy-2023-01-05/> -ээс Гаргасан

Монгол Улсын Гадаад Бодлогын үзэл баримтлал. (2011.). УБ.,